



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 1/226

Мөрөн сум

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 3 дугаар багт баригдсан "Хөвсгөл Титаник" ХХК-ийн үйлдвэрийн өргөтгөлийн барилгыг байнгын ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)

Д.Мягмарсүрэн (Мэргэжлийн хяналтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч)

П.Даваа-Очир (Мэргэжлийн хяналтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч)

Д.Аюушжав (Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Б.Гал-Эрдэнэ (Мэргэжлийн хяналтын газрын Харилцаа холбооны хяналтын улсын байцаагч)

Ж.Нацагдорж (Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч, хошууч)

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Ш.Баасанпүрэв (Мөрөн сумын архитектур, дэд бүтэц, нийтийн тээвэр хариуцсан мэргэжилтэн)

Б.Даваахүү (Мөрөн сумын Байгаль орчны байцаагч)

Д.Оюун-Эрдэнэ (Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Сүхээ ("Хөвсгөл Ус суваг" ХХК-ийн Ерөнхий инженер)

Д.Өлзийням ("Хөвсгөл Дулааны станц" ТӨХК-ийн Хяналтын инженер)

Х.Цанжидмонлом ("Хөвсгөл Эрчим хүч" ХХК-ийн Реле хамгаалалтын инженер)

Э.Дэлгэрмөрөн (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын геодезийн мэргэжилтэн)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Ц.Ганзоригт ("Органик архитектур монголиа" ХХК-ийн инженер)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

О.Баяраа ("ОВС" ХХК-ийн Захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Г.Лхагвасүрэн ("Хөвсгөл Титаник" ХХК-ийн Захирал)

Б.Пүрэвсүрэн ("Хөвсгөл Титаник" ХХК-ийн Ерөнхий инженер)

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Баасанжав (Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)


2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилга байгууламжийг ашиглалтад оруулсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав)-д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга, байгууламжийн ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР